

Тавдугаар зүйл

Томилсон улсын сулд бүхий хаягийг консулын газрын албан байранд хадах, улсынхаа далбааг консулын газрын байр, өөрийн еууц, албан хэрэгцээний автомашин дээр мандуулахыг консулд зөвшөөрнө.

Зургаадугаар зүйл

Консул ба консулын газрын ажилтан нар консулыг томилсон улсын иргэн болох учир албан уйл ажиллагааныхаа хувьд суугаа орны хууль зуйд ул захирагдана.

Доддугаар зүйл

Консул ба консулын газрын ажилтан нар албан уургээсээ гадуурах бух хэргийн талаар суугаа орны байгууллагуудад гэрчийн мэдүүлэг өх уурэгтэй. Хэрэв консул биеэр очиж чадахгүй бол гэрчийн мэдүүлгийг бичгээр буюу сууцандаа өгч болно. Хэрэв консул ирэхгүй бол туунийг урьсан бичиг нь шийтгэх зэрэг албадах бусад аргаар сурдуулсан утгатай байж ул болно.

Наймдугаар зүйл

1. Консул ба консулын газрын ажилтан нар консулыг томилсон улсын иргэд болох учир цэргийн ба бусад алба хаах, шууд татвар төлөхөөс чөлөөлөгдөнө. Татвараас чөлөөлөгдөх гэдэг нь суугаа оронд авч байгаа орлогот ул хамаарна*

2. Хэрэв консул ба консулын газрын ажилтан нар»томилсон орны иргэд бол эзэмшиж байгаа газар, байр нь зөвхөн албан байр, сууцанд ашиглагдаж байгаа бол тэдгээрийг цэргийн болон бусад албан уургээс чөлөөлнө.

3. Консул ба консулын газрын ажилтан нар, консулыг томилсон улсын иргэн бол гаалийн хураамжийн талаар дипломат төлөөлөгчдийн газрын ажилтан нарын адил харилцан тэгийг байх ундсэн дээр зохих хөнгөлөлт эдлэнэ.